



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/14/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Б.Должинжав

Утас: 89898557

цахим хаяг: Doljinjavb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
64000 Цэнхэр сум, Шаргалт сум, Ховд
Утас: 976-70433081, Факс: 976-70433081
E-mail: khovd@audit.gov.mn

БҮСИЙН ОНОШИЛГОО
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
П.ГЭРЭЛСҮРЭН ТАНАА

2022.02.25 № 2/116
тантай _____ -ны № _____ -г

ЗӨРЧИЛГҮЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

021020507

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	2
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа	14
4.3 Албан шаардлага	14
4.4 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОЗТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	406,331,697.84	4,126,303,274.37
33	АВЛАГА	7,210,611.00	3,614,926,891.80
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	7,210,611.00	3,050,259.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	3,611,876,632.80
35	БАРАА МАТЕРИАЛ	399,121,086.84	511,376,382.57
351	Түүхий эд материал	174,276,144.00	267,552,961.73
35110	Тусгай зориулалттай материал	68,240,798.00	81,829,699.03
35130	Эм боох материал	106,035,345.00	185,723,262.70
354	Хангамжийн материал	224,844,942.84	243,823,420.84
35410	Бичиг хэргийн материал	1,757,700.00	1,110,760.00
35420	Аж ахуйн материал	2,460,725.00	1,552,450.00
35440	Түлц, шатах тослох материал	6,230,000.00	2,562,718.00
35450	Барилгын засварын материал	1,070,000.00	3,544,000.00
35460	Хүнсний материал	9,303,140.00	5,042,000.00
35470	Бусад хангамжийн материал	204,023,377.84	230,011,492.84
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	29,704,100,659.95	32,333,159,857.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	29,704,100,659.95	32,333,159,857.96
392	Биет хөрөнгө	28,896,745,159.95	31,374,763,863.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	15,335,198,249.70	15,335,198,249.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	-865,081,136.27	-1,329,074,246.27
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,058,234,001.00	968,324,001.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-384,504,380.92	-397,632,079.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	18,119,522,778.47	22,851,783,488.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,905,945,422.20	-6,755,895,585.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	267,505,996.80	371,858,996.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-134,765,220.36	-163,294,828.02
39214	Бусад үндсэн хөрөнгө	971,093,769.00	1,133,940,439.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-574,519,710.27	-640,350,807.12
39217	Ном	6,235.00	6,235.00
393	Биет бус хөрөнгө	817,355,500.00	958,395,994.74
39301	Програм хангамж	30,015,000.00	172,836,189.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-28,887,500.00	-30,668,194.26
39303	Бусад биет бус хөрөнгө	816,228,000.00	816,228,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	30,110,432,357.79	36,459,463,132.33
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	724,077,229.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	724,077,229.00
413	Өглөг	00.00	724,077,229.00
4136	Бусад өглөг	00.00	724,077,229.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	724,077,229.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	30,110,432,357.79	35,735,385,903.33
51	Засгийн газрын хувь оролцоо	30,110,432,357.79	35,735,385,903.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,876,720,589.00	6,876,720,589.00
51101	Өмч - төрийн	6,876,720,589.00	6,876,720,589.00
512	Хуримтлагдсан үр дүн	15,440,674,032.09	21,065,627,577.63
51210	Өмнөх үеийн үр дүн	15,440,674,032.09	15,433,463,421.09
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	5,632,164,156.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,793,037,736.70	7,793,037,736.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	30,110,432,357.79	36,459,463,132.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төррөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	29,735,862,290.00	24,114,225,366.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,826,556,206.00	21,310,901,527.08
120	Нийтлэг татварын бус орлого	18,826,556,206.00	6,388,548,558.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,826,556,206.00	6,388,548,558.08
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	304,384,473.00	372,209,261.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,522,171,733.00	6,016,339,297.08
122	Тусламжийн орлого	00.00	14,922,352,969.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	14,922,352,969.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,909,306,084.00	2,803,323,839.66
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,283,833,600.00	912,321,120.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,283,833,600.00	912,321,120.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	242,985,370.00	1,441,002,719.66
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	40,775,428.66
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,370,000.00	110,332,091.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	149,016,000.00	1,220,660,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	63,599,370.00	69,235,200.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	450,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	00.00	260,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	190,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,382,487,114.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	5,382,487,114.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,153,159,256.84	18,482,061,210.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,153,159,256.84	18,482,061,210.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,123,751,897.34	17,933,440,210.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,393,014,637.00	7,584,866,935.80
210101	Үндсэн цалин	3,258,117,537.00	3,756,499,918.50
210102	Нэмэгдэл	2,391,175,900.00	3,045,549,116.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	266,805,000.00	254,123,100.50
210104	Урамшуулал	476,916,200.00	528,694,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	807,393,104.00	984,604,928.20

210201	Тэтгэврийн даатгал	514,071,262.00	698,216,497.50
210202	Тэтгэмжийн даатгал	83,837,617.00	71,192,314.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	72,665,143.00	56,954,191.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,659,312.00	14,238,422.00
210205	Эрүүл мэндийн даатгал	124,159,770.00	144,003,503.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	849,708,800.00	1,161,184,710.00
210301	Гэрэл, цахилгаан	158,521,895.00	211,544,752.00
210302	Түлш, халаалт	503,835,005.00	794,917,047.00
210303	Цэвэр, бохир ус	187,351,900.00	154,722,911.00
2104	Хангамж, бараа материалын зардал	151,112,817.00	200,313,783.50
210401	Бичиг хэрэг	44,602,155.00	44,709,450.00
210402	Тээвэр, шатахуун	97,922,305.00	149,848,807.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,588,357.00	5,515,526.50
210408	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	240,000.00
2105	Нормативт зардал	2,277,115,253.25	5,014,223,891.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,052,226,654.25	4,639,509,036.00
210502	Хоол, хүнс	224,888,599.00	374,714,855.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	383,170,033.80	449,580,940.91
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	378,000.00	600,000.00
210604	Урсгал засвар	382,792,033.80	448,980,940.91
2107	Томилолт, зочны зардал	11,418,100.00	3,732,800.00
210702	Дотоод албан томилолт	11,418,100.00	3,732,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,638,141.00	21,809,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,673,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,500,000.00	9,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,300,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,054,943.00	1,028,850.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,543,544.00	11,281,000.00
210807	Газрын төлбөр	566,654.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,233,181,011.29	2,513,122,370.79
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,233,181,011.29	2,513,122,370.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,407,359.50	548,621,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,100,000.00	548,621,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,100,000.00	548,621,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,307,359.50	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,307,359.50	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	16,582,703,033.16	5,632,164,156.54
5	НИЙТ ҮР ДҮН	16,582,703,033.16	5,632,164,156.54

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	6,876,720,589.00	7,793,037,736.70	-1,142,029,001.07	13,527,729,324.63
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,876,720,589.00	7,793,037,736.70	-1,142,029,001.07	13,527,729,324.63
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	16,582,703,033.16	16,582,703,033.16
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,876,720,589.00	7,793,037,736.70	15,440,674,032.09	30,110,432,357.79
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	6,876,720,589.00	7,793,037,736.70	15,440,674,032.09	30,110,432,357.79
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-7,210,611.00	-7,210,611.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,876,720,589.00	7,793,037,736.70	15,433,463,421.09	30,103,221,746.79
D08	Тайлант үеийн үр дүн			5,632,164,156.54	5,632,164,156.54
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,876,720,589.00	7,793,037,736.70	21,065,627,577.63	35,735,385,903.33

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	11,213,690,557.00	14,486,009,436.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	304,384,473.00	11,682,685,597.20
120	Нийтлэг татварын бус орлого	304,384,473.00	372,209,261.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	304,384,473.00	372,209,261.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	304,384,473.00	372,209,261.00
122	Тусламжийн орлого	00.00	11,310,476,336.20
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	11,310,476,336.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,909,306,084.00	2,803,323,839.66
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,283,833,600.00	912,321,120.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,283,833,600.00	912,321,120.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	242,985,370.00	1,441,002,719.66
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	40,775,428.66
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,370,000.00	110,332,091.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	149,016,000.00	1,220,660,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	63,599,370.00	69,235,200.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	450,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	00.00	260,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	190,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,382,487,114.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	5,382,487,114.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,213,690,557.00	14,486,009,436.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,213,690,557.00	14,486,009,436.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,184,283,197.50	13,931,538,436.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,350,419,004.00	7,505,863,091.00
210101	Үндсэн цалин	3,215,521,904.00	3,677,496,074.20
210102	Нэмэгдэл	2,391,175,900.00	3,045,549,116.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	266,805,000.00	254,123,100.00
210104	Урамшуулал	476,916,200.00	528,694,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	847,885,700.00	1,066,184,213.00
210201	Тэтгэврийн даатгал	598,512,100.00	781,414,766.00
210202	Тэтгэмжийн даатгал	62,343,400.00	71,192,314.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	49,874,700.00	56,954,191.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,468,700.00	14,238,422.00
210205	Эрүүл мэндийн даатгал	124,686,800.00	142,384,520.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	850,878,800.00	1,045,036,431.00
210301	Гэрэл, цахилгаан	158,521,800.00	211,544,752.00
210302	Түлш, халаалт	505,005,100.00	678,768,769.00
210303	Цэвэр, бохир ус	187,351,900.00	154,722,910.00
2104	Хангамж, бараа материалын зардал	208,387,200.00	251,719,017.50
210401	Бичиг хэрэг	34,781,000.00	27,207,800.00
210402	Тээвэр, шатахуун	105,244,600.00	132,072,425.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,194,600.00	6,005,222.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	38,500,000.00	48,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,667,000.00	37,933,570.00
2105	Нормативт зардал	2,310,906,101.50	3,638,654,967.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,040,687,401.50	3,252,326,602.70
210502	Хоол, хүнс	231,928,400.00	346,360,565.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	38,290,300.00	39,967,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	546,170,492.00	363,641,756.66
210601	Багаж, техник, хэрэгсэл	48,131,400.00	53,607,798.66
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,200,000.00	2,330,000.00
210604	Урсгал засвар	492,839,092.00	307,703,958.00
2107	Томиллолт, зочны зардал	11,203,900.00	3,732,800.00
210702	Дотоод албан томиллолт	11,203,900.00	3,732,800.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,432,000.00	56,706,160.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,000,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,673,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,500,000.00	9,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,300,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,055,000.00	8,918,850.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,256,000.00	13,068,000.00
210807	Газрын төлбөр	1,220,000.00	1,190,310.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,350,000.00	2,329,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,078,000.00	21,700,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,407,359.50	554,471,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,100,000.00	554,471,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,100,000.00	554,471,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,307,359.50	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,307,359.50	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,715,871,892.00	13,045,006,717.20	-670,864,974.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,715,871,892.00	13,045,006,717.20	-670,864,974.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,711,871,492.00	13,035,335,717.20	-676,535,774.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,505,863,091.00	7,505,863,091.00	00.00
210101	Үндсэн цалин	4,040,768,800.00	3,677,496,074.20	-363,272,725.80
210102	Нэмэгдэл	2,682,276,391.00	3,045,549,116.80	363,272,725.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	254,123,100.00	254,123,100.00	00.00
210104	Урамшуулал	528,894,800.00	528,894,800.00	00.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,066,184,213.00	1,066,184,213.00	00.00
210201	Тэтгэврийн даатгал	781,414,766.00	781,414,766.00	00.00
210202	Тэтгэмжийн даатгал	71,192,314.00	71,192,314.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	56,954,191.00	56,954,191.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	14,238,422.00	14,238,422.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	142,384,520.00	142,384,520.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,165,934,992.00	1,045,036,431.00	-120,898,561.00
210301	Гэрэл, цахилгаан	211,544,752.00	211,544,752.00	00.00
210302	Түлш, халаалт	784,734,231.00	678,768,769.00	-105,965,462.00
210303	Цэвэр, бохир ус	169,656,009.00	154,722,910.00	-14,933,099.00
2104	Хангамж, бараа материалын зардал	238,766,425.00	233,555,017.50	-5,211,407.50
210401	Бичиг хэрэг	26,632,800.00	26,632,800.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	132,072,425.00	132,072,425.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,894,200.00	6,005,222.50	-3,888,977.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	48,500,000.00	48,500,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,667,000.00	20,344,570.00	-1,322,430.00
2105	Нормативт зардал	3,480,718,358.00	2,957,341,621.70	-523,376,736.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,094,101,843.00	2,593,170,506.70	-500,931,336.30
210502	Хоол, хүнс	346,648,715.00	324,203,315.00	-22,445,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн, эдлэл	39,967,800.00	39,967,800.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	179,093,413.00	166,916,383.00	-12,177,030.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,914,400.00	17,607,370.00	-9,307,030.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	5,200,000.00	2,330,000.00	-2,870,000.00
210604	Урсгал засвар	146,979,013.00	146,979,013.00	00.00
2107	Томилголт, зочны зардал	9,000,000.00	3,732,800.00	-5,267,200.00
210702	Дотоод албан томилолт	9,000,000.00	3,732,800.00	-5,267,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,311,000.00	56,706,160.00	-9,604,840.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,500,000.00	9,500,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	9,500,000.00	8,918,850.00	-581,150.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,068,000.00	13,068,000.00	00.00
210807	Газрын төлбөр	2,020,000.00	1,190,310.00	-829,690.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,350,000.00	2,329,000.00	-21,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	21,700,000.00	21,700,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4000200.00	9671000.00	5,670,800.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000,200.00	9,671,000.00	5,670,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,200.00	9,671,000.00	5,670,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,715,871,692.00	13,045,006,717.20	-670,864,974.80
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,037,321,120.00	1,382,321,120.00	325,000,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	912,321,120.00	912,321,120.00	00.00
131008	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	125,000,000.00	450,000,000.00	325,000,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих			00.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			00.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,368,667,200.00	11,310,476,336.20	-1,058,190,863.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,368,667,200.00	11,310,476,336.20	-1,058,190,863.80
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	309,883,372.00	372,209,261.00	62,325,889.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	309,883,372.00	372,209,261.00	62,325,889.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	400.00	420.00	20.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00
620002	Гүйцэтгэх ажилтан	314.00	334.00	20.00
620003	Үйлчлэх ажилтан	85.00	85.00	00.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	242,985,370.00	1,441,002,719.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	242,985,370.00	1,441,002,719.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	242,985,370.00	896,202,719.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,080,804.00	00.00
210101	Үндсэн цалин	36,080,804.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,581,000.00	18,164,000.00
210401	Бичиг хэрэг	10,581,000.00	575,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		17,589,000.00

2105	Нормативт зардал	52,646,196.00	681,313,346.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	52,646,196.00	659,156,096.00
210502	Хоол, хүнс		22,157,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	124,677,370.00	196,725,373.66
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,217,000.00	36,000,428.66
210602	Тавилга	93,460,370.00	00.00
210604	Урсгал засвар		160,724,945.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,000,000.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,000,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	544,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		544,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		544,800,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	242,985,370.00	1,441,002,719.66
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	242,985,370.00	1,441,002,719.66
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		40,775,428.66
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,370,000.00	110,332,091.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	149,016,000.00	1,220,660,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	63,599,370.00	69,235,200.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамваралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал,

аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд эд хөрөнгийн тооллого, төсвийн хөрөнгийн үр ашиг, арвилан хэмнэлттэй холбоотой асуудлаар зөвлөмж өгсөн болно.

Аудитыг аудитор Б.Должинжав 2022 оны 02 дугаар сарын 15-нээс 02 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 1/36 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь "Бус нутгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чадварлаг багаар чанартай, аюулгүй, хүртээмжтэй үзүүлж, хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино." гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Тухайн онд ковид-19 вирусын нөхцөл байдлаас шалтгаалан Эрүүл мэндийн яамны дэргэдэх дотоод хяналтын албанаас санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Тус байгууллагын нягтлан бодогч нь байгууллагын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан ажиллаж байгаа хэдий тухайн баримт бичгийг боловсронгуй болгож шинэчлэн сайжруулах шаардлагатай байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд аудитын зорилго оршино.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг ажруул сууриар бүртгэж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлан гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөөлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, эрсдэлийн үнэлгээнээс хамаарч материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "бага" гэж үнэлсэн учир материаллаг байдлын түвшинг хамгийн ихээр буюу 2 хувиар тогтоосон.

Материаллаг байдлын түвшинг 2021 оны батлагдсан төсөв 13,715.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 274.3 сая төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 219.5 сая төгрөгөөр тогтоос.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,349.0 сая төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь авлага, үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Авлага дансны оны эхний үлдэгдэл 7.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 3,614.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 3,607.7 сая төгрөгөөр өссөн байна. Эцсийн үлдэгдэл дэх 3,614.9 сая төгрөгийн авлагын 3,611.9 сая төгрөг нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага, 3.1 сая төгрөг нь ҮЗ-д илүү шилжүүлсэн авлага байна.

Бараа материал данс оны эхэнд 399.1 сая төгрөг байсан бол оны эцэст 511.4 сая төгрөг болж 112.3 сая төгрөгөөр өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 4,562.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч, Эрүүл мэндийн яам, ХӨСҮТ, иргэд, аж ахуйн нэгжээс нийт 1,130.2 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч, 5,496.5 сая төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 83.8 сая төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны оны эхний үлдэгдэл 36,597.8 сая төгрөг байсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 256.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 4,886.1 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, 89.9 сая төгрөгийн хөрөнгө акталж данс бүртгэлээс хасаж, оны эцэст үндсэн хөрөнгийн данс 41,650.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Оны эхэнд өр төлбөргүй байсан бол тайлант оны эцэст 724.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өссөн байна. Эцсийн үлдэгдэл дэх 724.1 сая төгрөгийн 101.8 сая төгрөг нь түлш халаалтын өглөг, 15.0 сая нь цэвэр бохир усны өглөг, 29.4 сая төгрөг нь 13 компанитай холбоотой бараа үйлчилгээний зардлын өглөг, 577.9 сая төгрөг нь 17 компанитай холбоотой эмийн өр төлбөр байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 30,110.4 сая төгрөг байсан ба оны эцэст 35,735.4 сая төгрөг болж 5,625.0 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант үеийн үр дүн 5,632.2 сая төгрөгөөр нэмэгдсэн, өмнөх үеийн үр дүнд авлагатай холбоотой 7.2 сая төгрөгийн бууруулах залруулга хийсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны төсвийн нийт зардлыг анх 11,500.0 сая төгрөгөөр баталсан ба тодотголоор 2,215.9 сая төгрөг нэмэгдэж 13,715.9 сая төгрөгөөр батлагджээ.

Зардлыг санхүүжүүлэх ах үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 12368.7 сая, улсын төсвөөс 912.3 сая, дээд шатны төсвийн захирагчаас 125.0 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 309.9 сая, нийт 13,715.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 11,310.5 сая, улсын төсвөөс 912.3 сая, дээд шатны төсвийн захирагчаас 450.0 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 372.2 сая, нийт 13,045.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 13,045.0 сая төгрөг буюу 95.1 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 120.9 сая, хангамж, бараа материалын зардлын 5.2 сая, нормативт зардлыг 523.4 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 12.1 сая, томилолт, зочны зардлыг 5.3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 9.6 сая төгрөгөөр тус тус хэмнэж, урсгал шилжүүлгийн зардлыг 5.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу төсвийн байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Ковид-19-н сорьц, шинжилгээ, вакцин, эмчилгээний зардлын санхүүжилт 675.9 сая, Эрүүл мэндийн газраас нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн санхүүжилт 544.8 сая орон нутгийн төсвөөс 97.5 сая, онцгой байдлын газраас 12.8 сая, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 40.8 сая, төсвийн байгууллагын үйл ажиллагааны нэмэлт орлого 69.2 сая, нийт 1441.0 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн дээрх эх үүсвэрийг холбогдох арга хэмжээнд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамваралтай санхүүгийн тайланд толилуулаагүй дараах асуудал байна. Үүнд:

Ковидын PCR шинжилгээг 5 сараас 7 сарын хооронд 40.0 мянган, 80.0 мянган төгрөгийн төлбөртэй нийт 834 иргэдээс 52.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж ажилласан ба 7 сараас эхлэн Tandant.mn вэб сайт руу мэдээллийг шивдэг болсноор шивсэн мэдээллийн дагуу 1 иргэнд 50.0 мянган төгрөгөөр тооцож ЭМД-аас санхүүжилт олгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх дараах асуудал байна. Үүнд:

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлтэй холбоотой 2021 оны 3 дугаар сарын 01 ээс эхлэн эрүүл мэндийн байгууллагуудыг тохиолдлын тоогоор санхүүжүүлдэг болсноор ЭМДҮЗ-ын 2021 оны 3 дугаар тогтоол, 5 дугаар тогтоолыг баримтлан цахим шалгуур болон нэхэмжлэлийн шалгуураар тусламж үйлчилгээний санхүүжилтийг эхний 10 сар дуустал бүрэн авч, 11 дүгээр сар болон 12 дугаар сарын 10-ны өдөр хуртал тасалбар болгон үндсэн тусламж үйлчилгээ болон урьдчилан сэргийлэх үзлэгийн 1469.6 сая төгрөгийн санхүүжилт улсын хэмжээнд олгогдоогүй учир санхүүжилтийн авлага үүссэн байна.

2021 онд 21714 хүнд ковидын PCR шинжилгээ, 21790 хүнд сорьц цуглуулах шинжилгээ, 3668 хүнд ковидын вакцин, 3844 хүнд ковидын хэвтэн эмчилгээ хийснээр 7348.1 сая төгрөгийн санхүүжилтийг ЭМД-аас санхүүжүүлэхээр хянаж, эхний 10 сарыг дуустал 5205.9 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авснаар оны эцэст 2142.2 сая төгрөгийн санхүүжилтийн авлага үүссэн байна.

Дээрх санхүүжилтийн авлага 3611.9 сая төгрөгийн авлагыг Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй тооцоо нийлж баталгаажуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг иж бүрэн мэдээлээгүй байна. Үүнд: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогыг дутуу мэдээлсэн, 2020 оны бүтэн жилийн тайлан оруулах хэсэгт 2019 оны тайлан мэдээлсэн, 2020 оны аудитын дүгнэлт мэдээлээгүй зэрэг зөрчлийг аудитын явцад залруулж, зөрчлийг арилгууллаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 3.7 сая төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, зөвлөмжийн, албан шаардлагыг 70 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эмнэлгийн зориулалттай зарим тоног төхөөрөмжийг он дамжуулж хүлээн авч байгаагаас шалтгаалж данс бүртгэл, хөрөнгийн ашиглалтын бүрэн бүтэн байдалтай холбоотой асуудлыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 313.4 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс 120.2 сая төгрөгийн 2 алдаа, зөрчлийг залруулж, 126.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 66.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл зөрүүтэй тайлагнасан 41.2 сая, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг буруу ангилан бүртгэсэн 79.0 сая,
2. Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогыг дутуу мэдээлсэн, 2020 оны бүтэн жилийн тайлан оруулах хэсэгт 2019 оны тайлан мэдээлсэн, 2020 оны аудитын дүгнэлт мэдээлээгүй зэрэг зөрчлийг аудитын явцад залруулж, зөрчлийг арилгууллаа.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд нийт 120.2 сая төгрөгийн залруулга хийхийг шалгагдагч байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж шалгагдагч байгууллага тухайн бүртгэлийг залруулан 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 1/241 тоот албан бичгээр хариу ирүүлсэн.

4.3 Албан шаардлага

1. Мах нийлүүлэх тендерт шалгарсан Жаргалант шанд ХХК-аар тендерийн баталгааг хангуулаагүй, тендерийн үнээс өндөр үнээр мах худалдан авсан, Үүдэнгийн цагаан толгой хоршооноос чацаргана нийлүүлэх гэрээний үүргийг бүрэн хангаагүй, түүнчлэн бэлтгэн нийлүүлэгч компаниудын гэрээний үүргийн биелэлтийг дүгнээгүй зэрэг зөрчлүүд байна.

Шийдвэрлэсэн: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д "Дараах тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгоно", 20.7.2-д "«хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэлд заасан хугацаанд гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй, эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан", 15.1-д "Захиалагч тендер оролцогчоос гэрээний үүргийн биелэлтийг хангах санхүүгийн чадавхтайгаа баталсан нотолгоо ирүүлэхийг шаардаж болно", 49.2.10-д "тендерийн хавтаст хэрэгт гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй тул албан шаардлага өгөө.

2. Нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн сангийн 14.2 хувиар тооцон төлөөлөснөөс НДШ-ийн зардлаас 79.0 сая төгрөгийн цалингийн зардлыг гүйлгэн зарцуулсан, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайланд буруу тайлагнасан, бэлтгэн нийлүүлэгч компаниудтай байгуулсан гэрээний зарим нөхцөл тодорхойгүй зэрэг зөрчлүүд удаа дараа давтагдсан.

3. Данитос ХХК-аас 2017 онд худалдан авсан эмнэлгийн зориулалтын хулдаасны үлдэгдэл санхүүжилт 12.2 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулах зөвлөмжийг өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1.10-д "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллаагүй бол албан шаардлага өгнө" гэсэн заалтын хүрээнд шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Эд хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт. Эд хөрөнгийн тооллого хийсэн боловч хөрөнгийн тооллогыг балансны дүн, бүртгэл, тоо мэдээнд үндэслэн журам, стандартад нийцүүлэн хэрэгжүүлээгүй, хөрөнгийн тооллогын дүнд тооцоо бодож акт үйлдээгүй байна.

Өгсөн зөвлөмж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ". Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах". Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх, үүргийн хүрээнд нийцүүлэн дээрх зөрчлийг хойшид давтан гаргахгүй байх, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулахад анхаарч ажиллах.

2. Төсвийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт. Удирдлагын шийдвэргүйгээр эмнэлгийн оройн ээлжийн ажилтнууд, ковидын бүсэд ажилласан ажилтнуудын хоолны зардлыг өвчтөнүүдийн хоолны төсвөөс зарцуулсан. Тодруулбал дунджаар 1 өвчтөнд олгож буй хоолны зардлаас 2.5 дахин илүү буюу ээлжийн ажилчдын хоолны зардалд нийт 66.4 сая төгрөгийг ажилтны цалин хөлс, унаа хоолны олговортой давхардуулан зарцуулсан байна.

Өгсөн зөвлөмж. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", гэсэн заалттай нийцүүлж төсвийн хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Запуулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	БОЭТ	6	313.4	2	120.2			2	126.8	2	66.4

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Б.ДОЛЖИНЖАВ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022-02-25

Дугаар 19/А/217-0428

ХОН

ХОА-2022/14/НАА/СТА-ТШЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийхэд мах нийлүүлэх тендерт шалгарсан Жаргалант шанд ХХК-аар тендерийн баталгааг хангуулаагүй, тендерийн үнээс өндөр үнээр мах худалдан авсан, Үүдэнгийн цагаан толгой хоршооноос чацаргана нийлүүлэх гэрээний үүргийг бүрэн хангуулаагүй, түүнчлэн бэлтгэн нийлүүлдэгч компаниудын гэрээний үүргийн биелэлтийг дүгнээгүй зэрэг зөрчлүүд байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д "Дараах тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгоно", 20.7.2-д "«хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэлд заасан хугацаанд гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй, эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан", 15.1-д "Захиалагч тендерт оролцогчоос гэрээний үүргийн биелэлтийг хангах санхүүгийн чадавхтайгаа баталсан нотолгоо ирүүлэхийг шаардаж болно", 49.2 10-д "тендерийн хавтаст хэрэгт гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "шалаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал П.Гэрэлсүрэн, санхүү албаны дарга Ц.Олонбаяр, өрөнхий нягтлан бодогч Д.Баярсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР

Б ДОЛЖИНЖАВ

¹ Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагараа баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 05 сарын 25

Дугаар 18/А/217/0428

Ховд

ХОА-2022/14/НА/СТА-ТШЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийхэд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Данитос ХХК-аас 2017 онд худалдан авсан эмнэлгийн зориулалтын худдаасны үлдэгдэл санхүүжилт 12.2 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг оновчтой төлөвлөөгүй, бэлтгэн нийлүүлэгч компаниудтай байгуулсан гэрээний зарим нөхцөл тодорхойгүй зэрэг зөрчлүүд давтагдаж гарсан байна.

Иймд МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1.10-д "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллаагүй бол албан шаардлага өгнө", Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахагүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

3. Дээрх зөрчлийг арилгаж биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт² ирүүлэх.
4. Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал П.Гэрэлсүрэн, санхүү албаны дарга Ц.Олонбаяр, ерөнхий нягтлан бодогч Д.Баярсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР

Б.ДОЛЖИНЖАВ